

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, иргэн болон ажил олгогчид зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /цаашид “ХАБЭА” гэнэ/ сургалтын төрөл, зохион байгуулалт, хяналт үнэлгээ, тайлан мэдээтэй холбогдох харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нийцүүлэн зохицуулна.

1.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ХАБЭА-н сургалтын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавихад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

1.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага, их сургуультай хамтран ХАБЭА-н сургалтын байгууллагын багшид зориулсан сурган заах арга зүйн сургалтыг зохион байгуулна.

1.4.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н ажилтан, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг мэдээллээр хангах зорилгоор ХАБЭА-н сургалт, зөвлөх, аутсорсинг үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтэн, байгууллагын талаарх нээлттэй мэдээллийн сан /цаашид “нээлттэй мэдээллийн сан” гэнэ/-г үүсгэн хөтөлнө.

Хоёр. Сургалтын төрөл

2.1.Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, иргэн болон ажил олгогчид зориулсан ХАБЭА-н сургалт нь дараах төрөлтэй байна.

2.1.1.ажил олгогчийн сургалт;

2.1.2.нийт ажилтны сургалт;

2.1.3.эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилтанд зориулсан сургалт /цаашид “эрсдэлтэй ажлын байрны сургалт” гэнэ/;

2.1.4.хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалт;

2.1.5.ХАБЭА-н ажилтны сургалт.

2.2.Ажил олгогч болон аж ахуйн нэгж, байгууллагын бүх шатны удирдах албан тушаалтан энэхүү журмын 2.1.1-д заасан сургалтад жил бүр хамрагдаж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэгтэй болсон байна.

2.3.Ажил хөдөлмөр эрхэлж буй нийт ажилтан, иргэн энэхүү журмын 2.1.2-т заасан сургалтад жил бүр хамрагдаж аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс өөрийн

болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай мэдлэг, дадал эзэмшсэн байна.

2.4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг иргэн, ажилтан энэхүү журмын 2.1.3-т заасан сургалтад ажлын байрны эрсдэлийн шинж чанар, ажлын байрны онцлогоос шалтгаалан жил бүр хамрагдана.

2.5.Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмших зорилгоор энэхүү журмын 2.1.4-т заасан сургалтад жил бүр хамрагдана.

2.6.Энэхүү журмын 2.1.5-д заасан сургалтаар аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах ХАБЭА-н ажилтныг бэлтгэх бөгөөд байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомж, шаардлагын дагуу зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшсэн байна. ХАБЭА-н мэргэжлээр их, дээд сургууль төгссөн хүн энэ сургалтад хамаарахгүй.

2.7.ХАБЭА-н сургалтын байгууллага нь эрсдэл өндөртэй салбарын ХАБЭА-н ажилтныг тухайн чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж болно.

Гурав. Сургалтын хөтөлбөр

3.1.Ажил олгогч, нийт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан ХАБЭА-н сургалт зохион байгуулах байгууллага /цаашид “сургалтын байгууллага” гэнэ/ нь энэхүү журмын хавсралтаар баталсан жишиг хөтөлбөрт нийцүүлэн сургалтын төрөл бүрээр хөтөлбөр боловсруулан баталж, сургалтад ашиглана.

3.2.Эрсдэлтэй ажлын байрны сургалт, ХАБЭА-н ажилтны сургалт зохион байгуулах сургалтын байгууллага нь энэхүү журмын хавсралтаар баталсан жишиг хөтөлбөрт нийцүүлэн сургалтын төрөл бүрээр хөтөлбөр боловсруулж, мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагаар батлуулсан байна.

3.3.Сургалтын хөтөлбөр нь зорилго, агуулга, сургалтаар эзэмших цогц чадамж, мэдлэг, чадвар, хандлага, хичээлийн цаг, сэдвийн агуулга, төлөвлөгөө, сургалт удирдах багшийн мэдээлэл, сургалтын зохион байгуулалт, суралцагчийн үнэлгээ гэсэн агуулгатай байна.

3.4.Сургалтын хөтөлбөрт тусгасан суралцагчийн үнэлгээнд дараах нийтлэг шаардлага тавигдана.

3.4.1.ажил олгогч, нийт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалтад хамрагдаж, хичээлийн ирц 100 хувь, мэдлэг үнэлэх сорилд 75 хувиас багагүй дүн авсан бол сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно;

3.4.2.ХАБЭА-н ажилтны болон эрсдэлтэй ажлын байрны сургалтад хамрагдаж, хичээлийн ирц 100 хувь, мэдлэг үнэлэх сорилд 80 хувиас багагүй оноо, практик ур чадварын үнэлгээнд хангалттай дүн авсан бол төгссөнд тооцно.

3.5.Сургалтад хамрагдаж байгаа ажил олгогч, нийт ажилтан, иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрсдэлийн шинж чанар, ажлын байрны онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөрт нэмэлт агуулгыг оруулж болно.

3.6.Сургалтын байгууллага нь шинээр ажилд орж байгаа иргэн болон өөр ажлын байранд шилжиж байгаа ажилтны сургалтын хөтөлбөрийг эрсдэлийн шинж чанар, ажлын байрны онцлогт нийцүүлэн боловсруулна.

3.7.Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар боловсруулж болно.

Дөрөв. Сургалтын зохион байгуулалт

4.1.Сургалтын байгууллага нь хуулийн этгээд байх ба сургалтын чиглэлээр мэргэшсэн багшлах хүний нөөц, сургалтын анги танхим, дадлагын бааз эсхүл гэрээт байгууллагатай гэрээлсэн байна. Дадлага хичээлд Олон Улсын стандарт шаардлага хангасан орчин үеийн шинэлэг технологийг ашиглаж болно.

4.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын шаардлагад нийцүүлэн өөрийн ажлын байр, үйлдвэр, үйлчилгээний онцлогт тохируулан ажил олгогч, нийт ажилтан, эрсдэлтэй ажлын байрны сургалтыг зохион байгуулж болно.

4.3.Сургалтын байгууллага нь тухайн жилд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүний мэдээллийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

4.4.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь сургалтын байгууллагын дараах материалд үндэслэж, мэдээллийн сан үүсгэн хадгална.

4.4.1.ХАБЭА-н сургалтын төрөл бүрээр боловсруулж, батлуулсан сургалтын хөтөлбөр;

4.4.2.энэхүү журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5 д заасан заасан төрлөөр сургалтыг зохион байгуулах бол дадлага хичээлийн удирдамж;

4.4.3.багшийн анкет, боловсролын диплом, багшлах арга зүйн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

4.4.4.сургалтад элсэгч болон суралцагчдын бүртгэл, танхимын болон дадлага хичээлийн ирц, төгсөгчдийн мэдлэг, чадварыг үнэлсэн шалгалтын дүн, төгсөгчдийн бүртгэл, гэрчилгээний дугаар.

4.5.ХАБЭА-н сургалтын байгууллагад хичээл заах багш нь заах арга зүйн сургалтад хамрагдаж, чадвар эзэмшсэн ХАБЭА-н мэргэжилтэн байна.

4.6.Эрсдэлтэй ажлын байрны сургалтад хичээл заах багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн байна.

4.7.ХАБЭА-н ажилтны сургалтад хичээл заах багш нь дараах шаардлагыг хангана.

4.7.1.ХАБЭА-н мэргэжилтэн эсхүл мэргэжлийн цогц чадамжийг эзэмшсэн;

4.7.2.ХАБЭА-н чиглэлээр таваас доошгүй жилийн ажлын туршлагатай;

4.7.3.Онол, дадлага хичээл удирдах, заах арга зүйн чадвар эзэмшсэн, багшлах эрхийн үнэмлэх авсан.

4.8.Хөдөлмөрийн эрүүл ахуйн хичээл заах багш нь хөдөлмөрийн эрүүл ахуйн төрөлжсөн мэргэшилтэй байна.

4.9.Ажлын байран дахь анхны тусламжийн хичээлийг заах багш нь анхны тусламж үзүүлэгчийн гэрчилгээт сургалтыг дүүргэсэн, практик ажлын туршлагатай байна.

4.10.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н ажилтны сургалтад хамрагдсан суралцагчийн бүртгэл, мэдээлэл,

мэдлэг үнэлэх сорилын цахим системийг хөгжүүлж, 6 сар тутамд сорилын асуултыг шинэчилж, нууцлалыг хадгална.

4.11.Сургалтын байгууллага нь ХАБЭА-н ажилтны сургалтад элсэгч бүрийг энэхүү журмын 4.10-т заасан сорилын цахим системд бүртгүүлэх бөгөөд системээс суралцагч бүрд дахин давтагдахгүй бүртгэлийн дугаар олгоно.

4.12.ХАБЭА-н ажилтны сургалтад хамрагдсан суралцагч нь энэхүү журмын 4.10-т заасан сорилын цахим системээр шалгалт өгч хангалттай дүн авсан бол практик ур чадварын үнэлгээнд хамрагдах болзол хангана.

4.13.Сургалтын байгууллага нь ажил олгогч, нийт ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан ХАБЭА-н сургалтыг амжилттай дүүргэсэн төгсөгчдөд гэрчилгээ олгож болно.

4.14.ХАБЭА-н ажилтны сургалтын төгсөгчдөд олгох гэрчилгээнд дараах нийтлэг мэдээлэл бичигдэнэ.

- 4.14.1.Сургалтын байгууллагын нэр;
- 4.14.2.Суралцагчийн бүртгэлийн дугаар;
- 4.14.3.Суралцагчийн овог, нэр;
- 4.14.4.Сургалтын нэр: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны сургалт;
- 4.14.5.Хөтөлбөрийн агуулга, сургалтын цаг;
- 4.14.6.Сургалтад элссэн, төгссөн огноо;
- 4.14.7.Гэрчилгээний хүчинтэй хугацаа;
- 4.14.8.Гэрчилгээг баталгаажуулсан албан тушаалтны нэр, гарын үсэг.

4.15.Сургалтад хамрагдсан боловч шалгалтад тэнцээгүй, хангалтгүй дүн авсан суралцагч 1 удаа дахин шалгалт өгч болно.

4.16.ХАБЭА-н ажилтны сургалтыг төгсөгчдөд олгох гэрчилгээ нь 3 жилийн хугацаатай байх ба гэрчилгээний хугацааг сунгахын тулд ХАБЭА-н ажилтны мэдлэгийг үнэлэх сорилын цахим системийн давтан сорилын шалгалтад хамрагдана.

Тав. Хяналт үнэлгээ, тайлан мэдээ

5.1.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н сургалтын байгууллагад хийх хяналт, үнэлгээг хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу жил тутамд болон хүн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтийн дагуу мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, үр дүнг нийтэд нээлттэй мэдээлнэ.

5.2.Энэхүү журмын 5.1-т заасан хяналт үнэлгээний дүнг үндэслэн жил бүр сургалтын байгууллагын мэдээллийг нээлттэй санд байршуулна.

5.3.ХАБЭА-н сургалтын байгууллага нь сургалтын төрөл бүрээр элссэн, суралцсан болон төгссөн хүний тоон мэдээг эдийн засгийн салбар, аймаг, дүүргээр улирал бүр хавсралтад заасан загварын дагуу гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад илгээнэ.

5.4.Сургалтын байгууллага нь журмын 5.3-т заасан тоон мэдээг тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд 5.1-т заасан хяналт үнэлгээний дүнг бууруулж тооцох үндэслэл болно.

5.5.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н сургалтын статистик мэдээг улирал бүр нэгтгэн гаргаж, дараа сарын 21-ний өдрийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Бусад

6.1.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ХАБЭА-н ажилтны мэдлэг үнэлэх сорилын цахим системийг хөгжүүлж, сорилын нууцлал, системийн тасралтгүй, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

6.2.ХАБЭА-н ажилтны мэдлэг үнэлэх сорилын цахим систем ашиглахтай холбоотой шалгалтад хамрагдсан хүний мэдээллийг (овог, нэр, шалгалтын дүн, бүртгэлийн дугаар зэрэг) цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалахад холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

... оОо ...

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2025 оны ... дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ХИЙХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Сургалтын байгууллагын нэр:

Регистрийн дугаар:

Харилцах албан тушаалтны нэр:

Утасны дугаар:

И-мэйл:

Хаяг байршил:

Үнэлгээ хийсэн огноо:

Үнэлгээ хийсэн хүний нэр:

Зохион байгуулдаг сургалтын
төрөл:

☐ ажил олгогчийн сургалт

☐ нийт ажилтны сургалт

☐ эрсдэлтэй ажлын байрны сургалт

☐ хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалт

☐ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны сургалт

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Оноо
Сургалтын хөтөлбөр		
1.	Жишиг хөтөлбөртэй нийцсэн “Сургалтын хөтөлбөр” боловсруулан, мөрддөг (сургалтын хөтөлбөр бүрээр)	1
2.	Цаг сэдвийн төлөвлөгөөтэй (сургалтын хөтөлбөр бүрээр)	1
3.	Дадлага хичээлийн удирдамжтай ¹	1
4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны сургалтын суралцагчийн анкет, бүртгэлийг бүрдүүлж, хадгалдаг	1
5.	Хичээлийн ирцийн бүртгэл хөтөлдөг	1
6.	Суралцагчийн мэдлэг үнэлэх сорил, шалгалтын дүнгийн бүртгэл хөтөлдөг	1
Сургалтын орчин		
7.	ХАБЭА-н ажилтны сургалтын төгсөгчдийн дундаж дүн ²	20
8.	Сургалтын өрөө тасалгаа шаардлагатай хэрэгцээтэй тавилга, хэрэгслээр тоноглогдсон (ширээ, сандал, хичээл заахад ашиглах дэлгэц, проектор, самбар, бусад шаардлагатай зүйлс)	1
9.	Сургалтын өрөө тасалгаа, барилга нь ХАБЭА-н зохих шаардлага хангасан (аюулгүй ажиллагаа, онцгой үеийн болон анхны тусламж бэлэн байдлыг хангасан, хангалттай гэрэлтүүлэг, агааржуулалттай, шуугиан, тоос, хорт бодис зэрэг аюултай хүчин зүйлийн нөлөөлөлгүй...гэх мэт)	1
10.	Дадлага хичээлийн бааз, үзүүлэн таниулах материал нь сургалтын хөтөлбөрийн шаардлага хангасан ¹	1
11.	Дадлага хичээлийн үед суралцагчдыг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангаж, ХАБЭА-н зааварчилгаа өгдөг ¹	1
12.	Цахим сургалт хийдэг бол сургалтын контент нь хэрэглэгчид ээлтэй компьютер болон зөөврийн төхөөрөмжтэй нийцэж ажиллах боломжтой	1
13.	Цахим сургалт хийдэг бол багш болон суралцагч нь цахимаар харилцах боломжийг бүрдүүлсэн байх	1
14.	Сургалтын үзүүлэн (presentation), дадлага хичээлийн хөтөлбөрийн агуулгатай нийцсэн байх	1
15.	Сургалтын үзүүлэн (presentation), дадлага хичээлийн сэдэв нь шинжлэх ухааны үндэслэлтэй, практикт хэрэгцээтэй мэдлэгийг суралцагчид өгөхөд зориулагдсан	1
16.	Сургалтын үзүүлэн (presentation), дадлага хичээлийн удирдамжийг шинэчлэн сайжруулдаг (шинээр бий болсон сайн туршлага, технологи, стандарт, хууль тогтоомжийн шинэчлэл зэрэгтэй уялдуулан) байх	1
17.	Хувийн хамгаалах хэрэгсэл, тэмдэг, тэмдэглэгээ зэрэг үзүүлэн таниулах материал нь ХАБЭА-н стандартын шаардлагад нийцсэн байх	1
Багшлах бүрэлдэхүүн		

18.	Сургалтад ашиглах ном, гарын авлага, унших материалын жагсаалт, тэдгээрийг олж авах мэдээллээр суралцагчдыг хангадаг	1
19.	ХАБЭА-н мэргэжил эзэмшсэн эсхүл цогц чадамжийг эзэмшсэнийг нотлох баримт бичигтэй	5
20.	ХАБЭА-н мэргэжлийн үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлсэн	1
21.	Багшлах эрхийн үнэмлэхтэй эсхүл ХАБЭА-н сургагч багшийн сургалт ³ төгссөн	1
22.	Хөдөлмөрийн эрүүл ахуйн багш нь төрөлжсөн мэргэшлийн үнэмлэхтэй ³	1
Бүртгэл, мэдээлэл, тайлан		
23.	Анхны тусламжийн багш нь анхны тусламжийн гэрчилгээтэй, практик ажлын туршлагатай ²	1
24.	Сургалтад элссэн, суралцсан, төгссөн хүний тоон мэдээг журамд заасны дагуу мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад илгээдэг	4
25.	Олон нийтийн сургалт зохион байгуулдаг	1

¹ журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5-д заасан сургалт

² ХАБЭА-н ажилтны мэдлэгийг үнэлэх сорилын цахим системийн бүртгэлд үндэслэн үнэлнэ

³ ХАБЭА-н сургагч багшийн сургалт

Хяналт үнэлгээний дүн:

авбал зохих:..... оноо авсан:оноо авбал зохих оноос эзлэх хувь:....

Үнэлгээний баг:

ахлагч...../ /
 гишүүн...../ /
 гишүүн...../ /

Хяналт үнэлгээний дүнтэй танилцсан:

Сургалтын байгууллагын удирдлага/ /

Огноо: 20..... оны сарын өдөр

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын улирал тутмын тайлан мэдээний хуудас

ХАБЭА-н сургалтын байгууллагын нэр:

Сургалтын төрөл:.....

Тайлант хугацаа:.....

Тайлан хүлээлгэн өгсөн огноо:.....

A.

[illegible]¹Элссэн²Суралцсан

3Төгссөн

Б.

Сургалтад хамрагдсан хүний тоо	Нийт			Үүнээс эрэгтэй			15-24 нас			25-45 нас			46-60 нас		
Элссэн, суралцсан, төгссөн	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
Нийт															
Үүнээс Аймаг, дүүргээр															
Архангай															
Баян-Өлгий															
Баянхонгор															
Булган															
Говь-Алтай															
Говьсүмбэр															
Дархан-Уул															
Дорноговь															
Дорнод															
Дундговь															
Завхан															
Орхон															
Өвөрхангай															
Өмнөговь															
Сүхбаатар															
Сэлэнгэ															
Төв															
Увс															
Ховд															
Хөвсгөл															
Хэнтий															
Улаанбаатар															
Үүнээс: Баянгол															
Багануур															
Багахангай															
Баянзүрх															
Налайх															
Сонгинохайрхан															
Сүхбаатар															
Хан-Уул															
Чингэлтэй															

¹¹Элссэн

²Суралцсан

³Төгссөн

... oOo ...

100%

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийн нэг цагийн хичээлийн агуулгыг 45 минут байхаар тооцсон болно. Сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрөө салбар, эрсдэлийн шинж чанар, ажлын байр, мэргэжлийн онцлогт тохируулан боловсруулна.

Нэг. Ажил олгогчийн сургалтын хөтөлбөр

1.Хөтөлбөрийн зорилго:

Ажил олгогчийн сургалт нь аж ахуйн нэгж, байгууллагын бүх шатны удирдах албан тушаалтан байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөн, зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэгийг олгох зорилготой.

2.Сургалтаар эзэмшүүлэх мэдлэг, хандлага:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий мэдлэг;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг;
- Байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийн талаарх мэдлэг;
- ХАБЭА-н үйл ажиллагааг урьдчилан сэргийлэлтийн зарчмаар хэрэгжүүлэх хандлага.

3.Сургалтын агуулга:

Сэдэв 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн ойлголт:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн зорилго, хамаарах асуудалд;
- Ажлын байранд осол, өвчин үүсгэдэг аюултай хүчин зүйлс тэдгээрийн талаарх практик жишээ;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэдэг ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн практик жишээ;
- Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөх зарчим.

Сэдэв 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх захиргааны хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, акт;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн техникийн зохицуулалт, стандарт;
- ХАБЭА-н талаар ажил олгогч, ажилтны хуулиар хүлээсэн эрх, үүрэг.

Сэдэв 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт:

- ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, бүтцийн чиг үүрэг;
- ХАБЭА-н орон тооны бус зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах зарчим;

- ХАБЭА-н дотоод хяналт;
- Байгууллагын ХАБЭА-н арга хэмжээний төлөвлөлт, зохион байгуулалт, санхүүжилт, зардлын төрөл;
- Байгууллагын ХАБЭА-н соёл, ажил олгогчийн манлайлал, ажилтны оролцоо;
- ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалтын сайн жишээ.

Сэдэв 4. ХАБЭМ-ийн эрсдэлийн удирдлага:

- ХАБЭМ-ийн эрсдэлийн үнэлгээний хийх арга зүй;
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ;
- ХАБЭМ-ийн эрсдэлийг арилгах, бууруулах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний эрэмбэ;
- Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл;
- ХАБЭА-н сургалт, зааварчилгаа.

Сэдэв 5. Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт:

- Мэргэжлээс шалтгаалсан өвчин;
- Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэг;
- Ажилтны эрүүл мэндийн үнэлгээ, ажил мэргэжлийн тохиороо;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчний илрүүлэг, бүртгэл, мэдээлэл.

Сэдэв 6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл, мэдээлэл:

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах зарчим;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдолд дүн шинжилгээ хийж, дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, түүний хэрэгжилт.

4.Цаг, сэдвийн төлөвлөгөө:

Хөтөлбөрийн агуулгын хүрээнд цаг, сэдвийн төлөвлөгөөг боловсруулна.

5. Цагийн багтаамж: 6 цагаас доошгүй

6. Сургалтын зохион байгуулалт: Танхимын эсхүл цахим хэлбэр

7. Суралцагчийн үнэлгээ:

Дараах шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно:

- Сургалтын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих онолын мэдлэгийг сорилоор үнэлж, 75 хувиас багагүй оноо авсан бол хангалтайд тооцно;
- Суралцагч хөтөлбөрийн бүх агуулгыг бүрэн судалж, 100 хувийн ирцтэй байна.

Хоёр. Нийт ажилтны сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго:

Ажил хөдөлмөр эрхэлж буй нийт ажилтан, иргэнд аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс амь нас, эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н хууль эрх зүйн ойлголтыг өгөхөд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2. Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, хандлага:

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хүргэж болзошгүй аюулыг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх ерөнхий ойлголт;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчлөл үүсгэж болзошгүй ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх ерөнхий ойлголт;

- Хөдөлмөрийн болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх ерөнхий мэдлэг;
- Ажлын байран дахь осол, өвчлөлд хүргэж болзошгүй хүчин зүйлсийг илрүүлэх, мэдээлэх, арилгах арга хэмжээнд идэвхтэй оролцох хандлага.

3. Хөтөлбөрийн агуулга:

Сэдэв 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн ойлголт:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт, хамаарах асуудал;
- Ажлын байранд осол, өвчин үүсгэдэг аюултай хүчин зүйлс тэдгээрийн талаарх практик жишээ;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэдэг ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн практик жишээ;
- Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөх зарчим.

Сэдэв 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хөдөлмөрийн харилцааны суурь асуудал (хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, хэлэлцээр, ажил, амралтын цаг, цалин хөлс, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн маргаан зохицуулалт);
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- ХАБЭА-н талаар ажил олгогч, ажилтны хуулиар хүлээсэн эрх, үүрэг;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль.

Сэдэв 3. Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт:

- Ажлын байран дахь аюултай хүчин зүйлийн төрөл;
- Ажлын байрны эмх цэгц;
- Халтирах, бүдрэх, унах аюул;
- Цахилгааны аюул;
- Тоног төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой;
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой;
- Галын аюулгүй байдал;
- Химийн хортой ба аюултай бодисын хэрэглээ;
- Хязгаарлагдмал орчин;
- Өндөрт ажиллах;
- Ажлын оновчгүй зохион байгуулалт;
- Ажил гүйцэтгэх арга барил;
- Эргономикийн хүчин зүйлстэй холбоотой;
- Онцгой үеийн бэлэн байдал хангаагүйтэй холбоотой;
- Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөхгүй байх;
- Ажилтны эрүүл мэнд, биеийн байдал г.м;
- Ажлын байранд тохиолдсон үйлдвэрлэлийн ослын практик жишээнүүд;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх.

Сэдэв 4. Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийн төрөл, мэргэжлээс шалтгаалсан өвчин:

- Химийн хортой хүчин зүйлс: Эрдсийн болон органик тооснууд, гагнуурын тоосонцор, кварц цахиур, асбест, дэгдэмхий органик нэгдлүүд, хорт хий, уурнууд гэх мэт;

- Физикийн хүчин зүйлс: Шуугиан, доргион, халууны стресс, орчны хүйтэн температур, цацраг идэвхт туяа, цахилгаан соронзон цацраг, гагнуурын туяа (хэт ягаан туяа) гэх мэт;

- Биологийн хүчин зүйлс: Халдвартай хог хаягдал, бохир ус, халдвартай хүн, амьтантай ажиллах гэх мэт;

- Эргономикийн хүчин зүйлс: Хүнд зүйл өргөх, нэг маягийн олон давтагдсан хөдөлгөөн, албадмал байрлалд ажиллах гэх мэт;

- Түгээмэл тохиолддог мэргэжлээс шалтгаалах өвчин: Уушги тоосжих, тоостой холбоотой амьсгалын эрхтний өвчин, доргионы өвчин, шуугианы гаралтай сонсгол алдагдалд, химийн бодисын архаг, хурц хордлого, ажилтай холбоотой халдвар гэх мэт;

- Эрүүл мэндэд аюултай хүчин зүйлсийн өртөлтөөс хамгаалах удирдлага зохион байгуулалт, инженер технологи, хувь хүнд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ.

Сэдэв 5. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ:

- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зорилго, ач холбогдол;
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд;
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зохистой хэрэглээ.

Сэдэв 6. Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтан бүрийн үүрэг, оролцоо:

- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ;
- Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэх аюулыг таньж илрүүлэх;
- Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэх аюулыг холбогдох албан тушаалтанд мэдээлэх;
- Ажлын байранд аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ослыг тэглэхэд ажилтны гүйцэтгэх үүрэг, оролцоо.

Сэдэв 7. Ажил эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга, практик дадлага:

- Ажил эхлүүлэхийн өмнөх эрсдэлийн үнэлгээний ач холбогдол, хэрэглээ;
- Ажил эхлүүлэхээс өмнө ажлын байранд осол, өвчлөл үүсгэж болзошгүй аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх;
- Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн ажил эхлүүлэхтэй холбоотой шийдвэрийг гаргах арга.

Сэдэв 8. Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал:

- Онцгой байдлын тодорхойлолт, хамрах хүрээ;
- Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээний дэс дараа.

Сэдэв 9. Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж:

- Анхны тусламжийн тодорхойлолт, хамаарах асуудал;
- Анхны тусламжийн иж бүрдэл, түүний хэрэглээ;
- Ослын газарт нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж.

Сэдэв 10. Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт:

- Хувь хүний зан үйлтэй холбоотой үүсдэг халдварт бус өвчнүүд: Таргалалт, зүрх судасны өвчин, артерийн даралт ихсэлт, чихрийн шижин, хоол боловсруулах эрхтний өвчнүүд;
- Халдварт бус өвчин үүсгэхэд нөлөөлдөг зан үйлүүд: Согтууруулах ундаа, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, чихрийн их хэрэглээ, зохисгүй хооллолт;

- Эрүүл, аюулгүй орчинд ажиллах зан үйл, хандлагыг төлөвшүүлэх тухай.

4.Цаг, сэдвийн төлөвлөгөө:

Хөтөлбөрийн агуулгын хүрээнд цаг, сэдвийн төлөвлөгөөг боловсруулна.

5.Цагийн багтаамж: 8 цагаас доошгүй

6. Сургалтын зохион байгуулалт: Танхим

7. Суралцагчийн үнэлгээ:

Дараах шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно:

- Сургалтын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих онолын мэдлэгийг сорилоор үнэлж, 75 хувиас багагүй оноо авсан бол хангалтайд тооцно;
- Суралцагч хөтөлбөрийн бүх агуулгыг бүрэн судалж, 100 хувийн ирцтэй байна.

Гурав. Эрсдэлтэй ажлын байрны сургалтын хөтөлбөр

1.Хөтөлбөрийн зорилго:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилчдад аюулгүй ажиллах, осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох техник ашиглалтын дүрмийн шаардлагыг ханган ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай мэргэжлийн мэдлэг, ур чадварыг өгөхөд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2.Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, хандлага:

Эрсдэлтэй ажлын байрны сургалт нь тухайн ажил үүргийн онцлог шинж, учирч болзошгүй аюул осол, эрсдэл, түүнийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих талаар зайлшгүй шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэх, практик дадал олж авах болон холбогдох техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн агуулгыг багтаасан байна.

- Ашиглаж буй техник хэрэгсэл, түүхий эд материал, технологийн процессын талаарх мэдлэг, аюулгүй ашиглах ур чадварыг дээшлүүлэх;
- Ажлын үйл явц, ажлын байрны онцлогоос хамаарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод хүргэж болзошгүй аюулыг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэж болзошгүй ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх;
- Холбогдох хууль, дүрэм журам, стандартын талаарх мэдлэгийг бататгах;
- Ажлын байран дахь осол, өвчлөлд хүргэж болзошгүй хүчин зүйлсийг илрүүлэх, мэдээлэх, арилгах арга хэмжээнд идэвхтэй оролцох хандлага төлөвшүүлэх.

3.Эрсдэлтэй ажлын байрны сургалтын төрөл:

- Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа;
- Өргөх, зөөх, тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа;
- Ионжуулагч цацрагийн аюулгүй ажиллагаа;
- Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа;
- Биологийн халдвартай хог хаягдал, материалтай харьцах аюулгүй ажиллагаа;
- Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа;
- Хязгаарлагдмал орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагаа;
- Өндөр хэмийн ажил хийх үеийн аюулгүй ажиллагаа;
- Тусгаарлалтын үеийн аюулгүй ажиллагаа;
- Цахилгааны аюулгүй ажиллагаа;
- Бусад.

4.Хөтөлбөрийн агуулга:

4.1. Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Холбогдох техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм /сонголтоор/;
- Холбогдох техник ашиглалтын дүрэм /сонголтоор/;
- Холбогдох аюулгүй ажиллагааны дүрэм;
- Баллонд тавигдах шаардлага, аюулгүй ажиллагаа.

4.2. Өргөх, зөөх, тээвэрлэх механизмтай харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- ӨЗТМ-ын нэр төрөл, бүтэц зохион байгуулалт, онцлогууд;
- ӨЗТМ-ын аваар ослоос хамгаалах хэрэгслүүд тэдгээрт тавих хяналт;
- Оосорлох хэрэгслүүд, тэдгээрт тавигдах шаардлага, хяналт;
- Үйлдвэрлэлд ӨЗТМ ашиглах үеийн аюулгүй хүчин зүйлүүд, эрсдэлийн үнэлгээ;
- ӨЗТМ-ын техникийн байдал, аюулгүй ажиллагааг хянах техник технологи, түүний хэрэглээ;
- ӨЗТМ-ын аюулгүй ажиллагаа хариуцагчийн үүрэг, техник зохион байгуулалт, засвар угсралт;
- ӨЗТМ-ын засвар угсралтын ажлын төлөвлөлт зохион байгуулалт, засвар угсралтын ажлын дараах хяналт;
- ӨЗТМ-ын цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа.

4.3. Ионжуулагч цацрагийн аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Ионжуулагч цацрагийн тухай ерөнхий ойлголт;
- Ионжуулагч цацрагийн аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн зохицуулалт;
- Ионжуулагч цацрагийн хэрэглээ;
- Ионжуулагч цацрагаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- Ионжуулагч цацрагийн өртөлтийн тунг хэмжиж хянах аргууд;
- Цацрагийн аюулгүй байдлыг хангах үндсэн зарчим;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Ионжуулагч цацрагт өртсөн ажиллагчдын эрүүл мэндийн тандалт, мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

4.4. Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль, дүрэм, журам, олон улсын конвенц;
- Ажлын байранд ашиглахыг зөвшөөрсөн химийн хорт бодисын хор аюулын талаар;
- Хор судлалын ерөнхий ойлголт;
- Химийн бодисын таних тэмдэг, ангилал, хаяг шошго;

- Аюултай бодисыг шошголох, ангилах, бэлтгэхэд тавигдах ерөнхий шаардлага;
- Химийн бодисын өртөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэхэд ашиглагддаг зөвшөөрөгдөх дээд хэмжээний талаарх ойлголт;
- Химийн бодисын аюулгүй байдлын мэдээллийн лавлах;
- Химийн хорт ба аюултай бодисын тээвэрлэлт, хадгалалт;
- Уусгагчдын шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө;
- Металлын шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө;
- Химийн аюултай бодис;
- Химийн бодисын бүртгэл, менежмент.

4.5. Биологийн халдвартай хог хаягдал, материалтай харьцах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Биологийн аюултай хүчин зүйлсийн ангилал, шинж чанар: Бактери, мөөгөнцөр, вирус, шимэгч, генетикийн өөрчлөлттэй бичил биетэн;
- Микробиологийн эрсдэлийн үнэлгээ;
- Биологийн аюултай хог хаягдлын талаарх хууль эрх зүйн зохицуулалт;
- Био-аюулгүй байдлын зэрэглэлийн тодорхойлолт, ангилал;
- 1,2-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт, тоног төхөөрөмж, ажилтнуудад тавигдах эрүүл мэндийн тандалт, сургалт, хог хаягдал, хими, гал, цахилгаан, цацраг, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал;
- 3-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт, тоног төхөөрөмж, ажилтнуудад тавигдах эрүүл мэндийн тандалт;
- 4-р зэрэглэлийн Био-Аюулгүй байдал шаардах лабораторийн аюулгүй ажиллагаа: Заавал мөрдөх журам, лабораторийн зохион байгуулалт;
- Лабораторийн амьтантай харьцах үеийн аюулгүй ажиллагаа: 1, 2, 3 ,4-р түвшний Био-Аюулгүй байдал;
- Лабораторийн аюулгүй байдлын менежмент.

4.6. Өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Өндөрт ажиллах үеийн аюултай хүчин зүйлс, тэдгээрийг таньж илрүүлэх арга (онол болон дадлага хичээл);
- Өндрийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх (онол болон дадлага хичээл) Өндрөөс унахаас сэргийлэх хэрэгсэл, үзлэг шалгалт;
- Суурин бэхэлгээтэй ажлын тавцан, сагстай өргөгч, өргөх хайрцгийг аюулгүй ашиглах;
- Барилгын шат, задгай ирмэгийн хамгаалалт, хязгаарлах хэрэгсэл ба унахаас хамгаалах систем;
- Өндрөөс унаж болзошгүй биетийг хянах;
- Өндөрт гүйцэтгэх ажлыг багасгах инженерийн шийдэл, цогц арга хэмжээ;
- Өндөрт аврах ажиллагаа явуулах (онол болон дадлага хичээл).

4.7. Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Хязгаарлагдмал орчны тодорхойлолт, аюулууд;
- Хязгаарлагдмал орчинд мөрдөх аюулгүй ажиллагааны журам;
- Хязгаарлагдмал орчны аюулыг илрүүлэх, хяналт тавих арга хэмжээ арга (онол болон дадлага хичээл);
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх, ажиллах зөвшөөрөл олголт арга (онол болон дадлага хичээл);
- Хязгаарлагдмал орчны агаарын бохирдлын шинжилгээ, хяналт. Агаарын мониторингийн төхөөрөмж;
- Хязгаарлагдмал орчны цэвэрлэгээ ба ариутгал. Хязгаарлагдмал орчны агааржуулалт;
- Хязгаарлагдмал орчинд ашиглах аюулгүйн тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл;
- Зөөврийн цахилгаан төхөөрөмж, шингэн болон хийт төхөөрөмжийн ашиглалт;
- Хязгаарлагдмал орчинд ажиллах болон аврах багт тавигдах шаардлага, гүйцэтгэх үүрэг арга (онол болон дадлага хичээл);
- Хязгаарлагдмал орчинд нэвтэрч ажиллах ажилтнуудад хийх сургалт арга (онол болон дадлага хичээл).

4.8. Өндөр хэмийн ажил хийх үеийн аюулгүй ажиллагаа сургалтын хөтөлбөр

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Тухайн эрсдэлтэй ажлын байр бүр дэх хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлөл, урьдчилан сэргийлэлт;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Өндөр хэмийн ажлын тодорхойлолт, ажилд тавигдах шаардлага, хяналтын аргачлал;
- Өндөр хэмийн ажлын эрсдэлийг үнэлэх;
- Ажлын талбай бэлтгэх, ажлын зөвшөөрөл авах ба хаах;
- Тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагаа;
- Галын аюулгүй байдал.

4.9. Тусгаарлалтын үеийн аюулгүй ажиллагаа сургалтын хөтөлбөр

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;
- Тухайн эрсдэлтэй ажлын байр бүр дэх хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлөл, урьдчилан сэргийлэлт;
- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- Тусгаарлалтын үндсэн ойлголт /Аюултай энерги, аюултай бодисын тухай ойлголт, амь нас хамгаалах дүрэм/;
- Тусгаарлалтын хэрэгслүүд /Тусгаарлалтын ажилтны пайз, тусгаарлалтын хэрэгслийг зөв сонгох, найдвартай тусгаарлах тухай/;
- Эрсдэлийн үнэлгээний хэрэгслүүд, тусгаарлалтын зөвшөөрөл, тусгаарлалтын журам /Эрсдэлийн үнэлгээний хэрэгслүүд, тусгаарлалтын зөвшөөрөл, тусгаарлалтын журам, тусгаарлалтын матриц/;
- Тусгаарлалтын төрлүүд /Тусгаарлалтын төрлүүд-Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн тусгаарлалт, Суурин тоног төхөөрөмжийн тусгаарлалт, Тусгаарлалтын төрлүүд-Цахилгааны тусгаарлалт, Тусгаарлалтын ангилал/;

- Тусгаарлалтын үйл явц /Нэг цэгийн тусгаарлалтад цоожны хайрцгийн хэрэглээ, Олон цэгийн тусгаарлалт, олон цэгийн тусгаарлалтын алхмууд, Турших алхмыг гүйцэтгэх, Энергийн эх үүсвэрийн тусгаарлалтыг авах/;

- Энергийн эх үүсвэрийг салгаагүй тоног төхөөрөмж дээр хийгдэх ажил /Ашиглалтад оруулах ба Туршилт хийх пайз/;

- Тусгаарлалтын ажилтны түвшин, үүрэг хариуцлага /Тусгаарлалтын ажилтны түвшин, Тусгаарлалтын ажилтны үүрэг, хариуцлага, Тусгаарлалтын ажилтны эрх, үүрэг, Тусгаарлалтын ажилтны ур чадварын үнэлгээний бүртгэлийн дэвтэр, Томилгооны хуудас, Тусгаарлалтын ажилтны бүртгэл/;

- Тусгаарлалтын зөрчил /Тусгаарлалтын зөрчил гарсан үед авах арга хэмжээ, Эзэнгүй цоож эвдэх журам/.

4.10. Цахилгааны аюулгүй ажиллагаа

- ХАБЭА-н хууль дүрэм журам бусад хамаарах асуудлууд;

- Тухайн эрсдэлтэй ажлын байр бүр дэх хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлөл, урьдчилан сэргийлэлт;

- Тухайн ажил мэргэжилд хамаарах мэргэжлээс шалтгаалах өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

- Цахилгааны аюулгүй ажиллагааны үндсэн ойлголт;

- Цахилгаан гүйдлийн аюул. Цахилгааны осол. Цахилгааны ослын хүндрэлийн байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд;

- Тусгаарлагдсан саармагтай болон шууд газардуулсан гурван фазын цахилгаан сүлжээний аюултай байдал;

- Нэг фазын сүлжээний аюултай байдал, схемийн онцлогууд;

- Цахилгаан гүйдэл газардах үзэгдэл. Хүрэх хүчдэл. Алхмын хүчдэл;

- Үйлдвэрлэлийн болон ажлын байр, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний цахилгааны аюулгүй ажиллагааны нөхцөл, тэдгээрийн ангилал;

- Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн ялгаа, онцлог, хэрэглэх хүрээ;

- Цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжийн тусгаарлал, цахилгаан тусгаарлалын байдалд тавих хяналтын техник, зохион байгуулалтын арга хэмжээ;

- Бага хүчдэл хэрэглэх. Цахилгааны аюулгүй ажиллагааны хориг түгжээ;

- Хамгаалах газардуулга, газардуулгын байгууламжийн бүтэц, хийц. Хамгаалах газардуулгын тооцоо, үзлэг, хяналт, хэмжилт;

- Нойлтуулга, түүний бүтэц, хийц. Нойлтуулгын тооцоо, хяналт;

- Хамгаалах таслалт, түүнийг хэрэглэх хүрээ. Хамгаалах таслалтын схемүүд;

- Цахилгаанаас хамгаалах хэрэгсэл, тэдгээрийн ялгаа, ангилал, хэрэглэх хүрээ, цахилгааны аюулгүй ажиллагааны анхааруулах, хориглох, зөвшөөрөх, сануулах плакат

- Цахилгаан техникийн ажилтанд тавих шаардлага. Цахилгааны аюулгүй ажиллагааны мэргэшлийн групп. Цахилгааны осолд орсон хүнийг хүчдэлээс чөлөөлөх, осолдогчийн биеийн байдлыг тодорхойлох, анхны тусламж үзүүлэх.

5. Сургалтын зохион байгуулалт:

Сургалтын төрлөөс хамаарч танхим болон ажлын байранд онол, дадлага хэлбэрээр зохион байгуулагдана.

6. Цагийн багтаамж:

Сургалт бүр нь 12 цагаас доошгүй багтаамжтай байна.

7. Суралцагчийн үнэлгээ:

Дараах шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно:

- Суралцагч хөтөлбөрийн бүх агуулгыг бүрэн судалж, 100 хувийн ирцтэй;

- Сургалтын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих онолын мэдлэгийг сорилоор үнэлж, 80 хувиас багагүй оноо авсан;
- Дадлага хичээлтэй сургалтын хувьд практик ур чадварын үнэлгээнд хангалтай дүн авсан байна.

Дөрөв. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн зорилго:

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг өгөхөд энэхүү хөтөлбөр чиглэнэ.

2.Хөтөлбөрийн агуулга:

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний сургалт нь аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н талаарх ерөнхий ойлголт, хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, салбарын онцлог, эрсдэлийн шинж чанарт тохирсон ХАБЭА-н талаарх агуулгыг багтаасан байна.

3.Сургалтаар эзэмшүүлэх мэдлэг, хандлага:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий мэдлэг;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг;
- Байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийн талаарх мэдлэг;
- ХАБЭА-н үйл ажиллагааг урьдчилан сэргийлэлтийн зарчмаар хэрэгжүүлэх хандлага.

4.Сургалтын агуулга:

Сэдэв 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн ойлголт:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зорилго, хамаарах асуудал;
- Ажлын байранд осол, өвчин үүсгэдэг аюултай хүчин зүйлс тэдгээрийн талаарх практик жишээ;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэдэг ажлын байрны хими, физик, биологи, эргономикийн сөрөг хүчин зүйлс, тэдгээрийн практик жишээ;
- Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол, мэргэжлээс шалтгаалсан өвчин;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөрдөх зарчим.

Сэдэв 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн техникийн зохицуулалт, стандарт;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм;
- Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэг;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчний илрүүлэг, бүртгэл, мэдээлэл.

Сэдэв 3. Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт:

- Ажлын байран дахь аюултай хүчин зүйлийн төрөл;
- Халтирах, бүдрэх, унах аюул;
- Цахилгааны аюул;
- Тоног төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой;

- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой;
- Галын аюулгүй байдал;
- Химийн хортой ба аюултай бодисын хэрэглээ;
- Хязгаарлагдмал орчин;
- Өндөрт ажиллах;
- Ажлын оновчгүй зохион байгуулалт;
- Ажил гүйцэтгэх арга барил;
- Эргономикийн хүчин зүйлстэй холбоотой;
- Онцгой үеийн бэлэн байдал хангаагүйтэй холбоотой;
- Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөхгүй байх;
- Ажилтны эрүүл мэнд, биеийн байдал г.м;
- Ажлын байранд тохиолдсон үйлдвэрлэлийн ослын практик жишээнүүд;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос сэргийлэх.

Сэдэв 4. Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийн төрөл, мэргэжлээс шалтгаалсан өвчин:

- Химийн хортой хүчин зүйлс: Эрдсийн болон органик тооснууд, гагнуурын тоосонцор, кварц цахиур, асбест, дэгдэмхий органик нэгдлүүд, хорт хий, уурнууд гэх мэт;
- Физикийн хүчин зүйлс: Шуугиан, доргион, халууны стресс, орчны хүйтэн температур, цацраг идэвхэд туяа, цахилгаан соронзон цацраг, гагнуурын туяа (хэт ягаан туяа) гэх мэт;
- Биологийн хүчин зүйлс: Халдвартай хог хаягдал, бохир ус, халдвартай хүн, амьтантай ажиллах гэх мэт;
- Эргономикийн хүчин зүйлс: Хүнд зүйл өргөх, нэг маягийн олон давтагдсан хөдөлгөөн, албадмал байрлалд ажиллах гэх мэт;
- Түгээмэл тохиолддог МШӨ: Уушги тоосжих, тоостой холбоотой амьсгалын эрхтний өвчин, доргионы өвчин, шуугианы гаралтай сонсгол алдагдалд, химийн бодисын архаг, хурц хордлого, ажилтай холбоотой халдвар гэх мэт;
- Эрүүл мэндэд аюултай хүчин зүйлсийн өртөлтөөс хамгаалах удирдлага зохион байгуулалт, инженер технологи, хувь хүнд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ.

Сэдэв 5. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ:

- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зорилго, ач холбогдол;
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд;
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн зохистой хэрэглээ.

Сэдэв 6. Ажил эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга, практик дадлага:

- Ажил эхлүүлэхийн өмнөх эрсдэлийн үнэлгээний ач холбогдол, хэрэглээ;
- Ажил эхлүүлэхээс өмнө ажлын байранд осол, өвчлөл үүсгэж болзошгүй аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх;
- Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн ажил эхлүүлэхтэй холбоотой шийдвэрийг гаргах арга.

Сэдэв 7. Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал:

- Онцгой байдлын тодорхойлолт, хамрах хүрээ;
- Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээний дэс дараа.

Сэдэв 8. Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж:

- Анхны тусламжийн тодорхойлолт, хамаарах асуудал;
- Анхны тусламжийн иж бүрдэл, түүний хэрэглээ;
- Ослын газарт нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ;

- Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж.

4.Цаг, сэдвийн төлөвлөгөө:

Хөтөлбөрийн агуулгын хүрээнд цаг, сэдвийн төлөвлөгөөг боловсруулна.

5. Цагийн багтаамж: 6 цагаас доошгүй

6. Сургалтын зохион байгуулалт: Танхимын эсхүл зайн хэлбэрээр

7. Суралцагчийн үнэлгээ:

Дараах шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно:

- Сургалтын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих онолын мэдлэгийг сорилоор үнэлж, 75 хувиас багагүй оноо авсан бол хангалтайд тооцно;
- Суралцагч хөтөлбөрийн бүх агуулгыг бүрэн судалж, 100 хувийн ирцтэй байна.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр

1.Хөтөлбөрийн зорилго:

Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжийн шаардлагын дагуу зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

2.Сургалтаар зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлага:

Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомжийн шаардлагын дагуу зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

2.1. Мэдлэг:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын талаарх ойлголт;
- Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлсийн шинж чанар, тэдгээрээс үүсэх осол, хордлого, өвчний талаарх суурь мэдлэг;
- Ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалт, ХАБЭА-ын сургалтын зохион байгуулалтын талаарх ерөнхий ойлголт;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг;
- Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн бүтэц, зохион байгуулалтын талаарх суурь мэдлэг.

2.2. Чадвар:

- ХАБЭА-н үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартыг мөрдөж ажиллах;
- ХАБЭА-н талаарх байгууллагын журам, баримт бичгийг боловсруулах;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр нөлөөг нь үнэлэх;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг үүсгэх аюул, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлсийн удирдлага, холбогдох албан тушаалтан, нийт ажилтанд

үнэн зөвөөр тохиромжтой арга хэлбэрээр таниулан ойлгуулах сургалт, зааварчилгаа, аюулыг мэдээлэх харилцааг үр дүнтэй зохион байгуулах;

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг судлан бүртгэх, шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх;

- Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, тандалтын зохион байгуулалтад хяналт тавих.

2.3. Хандлага:

- Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ёс зүйтэй, хуулийн хүрээнд ажиллах;

- ХАБЭА-н үйл ажиллагааг урьдчилан сэргийлэлтэд суурилсан зарчмаар хэрэгжүүлэх;

- ХАБЭА-н үйл ажиллагааг нотолгоо баримтад үндэслэн төлөвлөж, үнэлэх.

3.Хөтөлбөрийн агуулга:

Модуль 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удиртгал

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх үндсэн ойлголт;
- Ажлын байранд дахь аюултай хүчин зүйлс, тэдгээрээс үүсэх эрсдэл;
- ХАБЭМ-ийн мэргэжилтний үүрэг, мэргэжлийн ёс зүй;
- Монгол Улс дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоо, зохион байгуулалт;

- Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн техникийн зохицуулалт, стандарт;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мөрдөх дүрэм, журам.

Цагийн багтаамж: 8 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар

Модуль 2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэс

- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай үндсэн ойлголт, зорилго;
- Үйлдвэрлэлийн осол үүсгэдэг аюултай хүчин зүйлс;
- Үйлдвэрлэлийн суурь машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал;
- Цахилгааны аюулгүй ажиллагаа;
- Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа;
- Барилгын аюулгүй ажиллагаа;
- Өндрийн аюулгүй ажиллагаа;
- Даралтат хий, савны аюулгүй ажиллагаа;
- Материал, түүхий эдтэй харьцах ажиллагаа;
- Ухалт малталтын аюулгүй ажиллагаа;
- Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, аюултай хүчин зүйлсийн ангилал;
- Түгжих, пайзлах (Lockout and Tag out);
- Ажлын байран дахь танилцах дадлага (дадлага хичээлтэй).

Цагийн багтаамж: 32 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг ажлын байрны бодит орчинд эсвэл хиймэл бодит (virtual reality) орчинд явуулж болно.

Модуль 3. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үндэс

- Хөдөлмөрийн эрүүл ахуйн суурь ойлголт;
- Ажлын байрны агаар дахь тоос, хорт бодисын өртөлт, тэдгээрээс шалтгаалсан өвчлөлийн урьдчилан сэргийлэлт;
- Ажлын байран дахь физикийн хүчин зүйлсийн өртөлт, тэдгээрээс шалтгаалсан өвчлөлийн урьдчилан сэргийлэлт: доргион, шуугиан, ионжуулагч цацраг, бичил цаг уур, дулааны стресс;
- Ажлын байран дахь эргономикийн хүчин зүйлс, тэдгээрээс шалтгаалсан яс булчин, холбогч эдийн эмгэгийн урьдчилан сэргийлэлт;
- Ажлын байран дахь биологийн аюултай хүчин зүйлс, өртөлтөөс урьдчилан сэргийлэх зарчим;
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийн арга зүй (дадлага хичээлтэй);
- Хор судлалын тухай ерөнхий ойлголт, хөдөлмөрийн эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- Химийн хортой ба аюултай бодисын ангилал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, зохион байгуулалт;
- Ажилтны эрүүл мэндэд тавигдах шаардлага, ажил хөдөлмөрийн тохироо;
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт.

Цагийн багтаамж: 24 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг сургалтын танхим эсвэл эрүүл ахуйн хэмжилтийн багаж ашиглаж явуулна.

Модуль 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн удирдлага

- ХАБЭМ-ийн эрсдэлийн үнэлгээний арга зүй: Аюулыг илрүүлэх, өртөлтийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ (дадлага хичээлтэй);
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ;
- Эрсдэлийн удирдлага: Аюулыг арилгах, орлуулах инженерийн хяналт, удирдлага зохион байгуулалт, хувь хүнд чиглэсэн арга хэмжээ;
- Эрсдэлийн удирдлагын төлөвлөлт, хэрэгжилт, мониторинг, сайжруулалт;
- Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн сайн туршлагын жишээ.

Цагийн багтаамж: 8 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг ажлын байрны бодит орчинд эсвэл хиймэл бодит (virtual reality) орчинд явуулж болно.

Модуль 5. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн зохистой хэрэглээ

- Хувийн хамгаалах хэрэгслийн талаарх суурь ойлголт, сонголт, зохистой хэрэглээ;
- Нүд, нүүр хамгаалах хэрэгсэл;
- Амьсгал хамгаалах хэрэгсэл;
- Сонсгол хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага;
- Толгой, гар, хөл хамгаалах хэрэгсэл, тавигдах шаардлага;
- Ажилтнуудын хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох, тохиромжтой байдал, үр нөлөөг үнэлэх (дадлага хичээлтэй);
- Ажилтнуудад зориулсан ХХХ-ийн хэрэглээний талаарх сургалт, зааварчилгаа.

Цагийн багтаамж: 8 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг ажлын байрны бодит орчинд эсвэл хиймэл бодит (virtual reality) орчинд явуулж болно.

Модуль 6. Эрсдэлийн харилцаа, ХАБЭА-н сургалт,

- Эрсдэлийн харилцааны тухай үндсэн ойлголт;
- ҮОМШӨ үүсгэх аюулыг мэдээлэх арга, хэлбэр, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь;
- ХАБЭА-н тэмдэг, тэмдэглэгээний ангилал;
- Аюултай бараа, материалын шошго, тэмдэглэгээ;
- Хор аюулын лавлах мэдээлэл;
- Эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг удирдах албан тушаалтан, ажилтнуудад мэдээлэх, танилцуулах дадлага хичээл (дадлага хичээлтэй);
- Ажил олгогчийн болон ажилтанд ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах арга зүй;
- Сурган заах арга зүйн дадлага хичээл;
- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа (дадлага хичээлтэй).

Цагийн багтаамж: 16 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг ганцаарчилсан болон жижиг бүлгээр даалгаврыг биелүүлэх, сургалтын үзүүлэн, материал бэлтгэх, хичээл заах байдлаар явуулж болно.

Модуль 7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан, бүртгэх дүрэм;
- Үйлдвэрлэлийн осол хурц, хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын ажиллах журам;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх акт, бүрдүүлэх баримт бичиг, баталгаажуулалт (дадлага хичээлтэй);
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлыг шалтгааныг тодорхойлох, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах дүн шинжилгээ (дадлага хичээлтэй);
- Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлэх, онош баталгаажуулалт, бүртгэл, мэдээлэл.

Цагийн багтаамж: 6 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг өгөгдсөн бодит тохиолдлын жишээ даалгаврыг биелүүлэх байдлаар явуулна.

Модуль 8. Анхны тусламж, түүний бэлэн байдал

- Анхны тусламжийн тухай ерөнхий ойлголт, анхны тусламж үзүүлэхэд анхаарах зүйлс;
- Анхны тусламжийн иж бүрдэл, түүний хэрэглээ, ажлын байран дахь анхны тусламжийн иж бүрдлийн шаардлагууд;
- Осол гэмтэл, гэнэтийн өвчлөлд нэрвэгдсэн хүнийг үнэлэх;
- Амилуулах суурь тусламж;
- Автомат тохируулгат дефибриллятор, түүний хэрэглээ;
- Хахалтын үед үзүүлэх анхны тусламж;
- Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж;
- Хугарал, зөөлөн эдийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж;

- Хордлогын үед үзүүлэх анхны тусламж;
- Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж;
- Гэнэтийн өвчлөл (таталт, зүрхний шигдээс, харвалт);
- Нуруу нугасны гэмтлийг үнэлэх, нуруу нугасны гэмтэлтэй осолдогчийг хамгаалах аргууд.

Цагийн багтаамж: 8 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар явуулна;
- Дадлага хичээлийг танхимаар явуулах бөгөөд суралцагчид багшийн зааварчилгааны дагуу өөрсөд дээрээ хийж үзэх ба тусгайлан бэлтгэсэн шалгуур хуудасны дагуу суралцагчдыг үнэлнэ;
- Амилуулах суурь тусламжийн дадлага хичээлийг сургалтын манекен ашиглан, суралцагч нэг бүр хийж үзэх байдлаар зохион байгуулна;
- Ажлын байран дахь ослын тохиолдлыг жүжигчилсэн байдлаар дүрд орж суралцагчид тохиолдол дээр ажиллана.

Модуль 9. Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал, галын аюулгүй ажиллагаа

- Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт;
- Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал;
- Байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага, түүний эрх зүйн зохицуулалт;
- Гамшгаас хамгаалах төлөвлөлт;
- Галын аюулгүй байдлын тухай ойлголт;
- Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах нь.

Цагийн багтаамж: 4 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;

Модуль 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоо

- Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭМ-ийн үйл ажиллагаанд тавигдах хууль тогтоомжийн шаардлага;
- Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н бүтэц, зохион байгуулалт, асуудал хариуцсан ажилтан, орон тооны бус зөвлөлийн чиг үүрэг;
- ХАБЭА-н талаар байгууллагын бодлого, журам, удирдлагын манлайлал, ажилтны оролцоо;
- ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн үнэлгээ, санхүүжилт (дадлага хичээлтэй);
- ХАБЭА-н гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод хяналт шалгалт (дадлага хичээлтэй);
- ХАБЭА-н менежментийн олон улсын сайн туршлага .

Цагийн багтаамж: 12 цагаас багагүй

Хичээлийн хэлбэр:

- Лекцийн хичээлийг танхим эсвэл зайн сургалтаар;
- Дадлага хичээлийг өгөгдсөн бодит тохиолдлын жишээ даалгаврыг биелүүлэх байдлаар явуулна.

4.Цаг, сэдвийн төлөвлөгөө:

Хөтөлбөрийн агуулгын хүрээнд цаг, сэдвийн төлөвлөгөөг боловсруулна.

5. Сургалтын нийт цаг: 124 цагаас доошгүй

6. Суралцагчийн үнэлгээ:

Дараах шалгуурыг хангасан суралцагчийг сургалтыг амжилттай дүүргэсэнд тооцно:

- Суралцагч хөтөлбөрийн бүх агуулгыг бүрэн судалж, 100 хувийн ирцтэй;
- Сургалтын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих онолын мэдлэгийг сорилоор үнэлж, 80 хувиас багагүй оноо авсан;
- Практик ур чадварын үнэлгээнд хангалттай дүн авсан бол төгссөнд тооцно.

... оОо ...